



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

“Авлигын эсрэг үйл ажиллагааны
төлөвлөгөө” батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг үндэслэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Авлигын эсрэг хуулийн 5, 6 дугаар зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрчим хүчний яамны 2017 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.


2. Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад анхаарч, биелэлтэд нь байнгын хяналт тавьж, үр дүнг 12 дугаар сарын 25-ны дотор Төрийн захиргааны удирдлагын газарт тайлагнаж ажиллахыг газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Төрийн нарийн бичгийн дарга /З.Мэндсайхан/-д даалгасугай.



П.ГАНХҮҮ

008000238



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ 2017 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хэрэгжүүлэх ажил/арга хэмжээ		Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн	Тайлбар
1	Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах	2017 оны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг АТГ-ын ажлын албанд хүргүүлэх	2018.02.01-ний дотор	Хуулийн хэлтсийн дарга ЭБАТ Н. Бямбадорж	
		Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах /хэрэгжилтийг бүрэн тайлагнах/	Жилдээ	Хуулийн хэлтсийн дарга ЭБАТ Н. Бямбадорж	
		Тайлан, нотлох баримтыг тогтоосон хугацаанд АТГ-т хүргүүлэх	2017.11.10	Хуулийн хэлтсийн дарга ЭБАТ Н. Бямбадорж	
2	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах	Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх талаар ажилтнуудад танилцуулгах Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, яриа танилцуулга, теле сурталчилгаа, сонсгол,	Тухай бүр	Хуулийн хэлтсийн дарга ЭБАТ Н. Бямбадорж	

		нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал гм/ Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллагад түгээн ажилласан байх			
3	Салбарын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг цахим хуудсанд байршуулах,	Шинээр мөрдөгдөх дүрэм, журмыг цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	XX-ийн АХлах мэргэжилтэн Ц.Цогзолмаа ТЗУГ-ын мэргэжилтэн Б.Түмэнжаргал	
		Эрчим хүчний сайдын 2017 оны тушаалыг бүрэн эхээр нь /нууцад хамаарахаас бусад/ дугаарлалтын дагуу цахим хуудсанд байршуулах	Тушаал гарсан даруй	Сайдын туслах Ж.Товуудорж ТЗУГ-ын мэргэжилтэн Б.Түмэнжаргал	
		Төрийн нарийн бичгийн 2017 оны тушаалыг бүрэн эхээр нь /нууцад хамаарахаас бусад/дугаарлалтын дагуу цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	ТНБД-ын туслах Ж.Баттулга ТЗУГ-ын мэргэжилтэн Б.Түмэнжаргал	
4	Шинээр боловсруулж буй хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийт,	Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа	Тухай бүр	Яамны газрууд	

	сонирхогч бүлгээр хэлэлцүүлэх, тэдний саналыг тусгах	байршуулсан байх			
		Эдгээр төсөл иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах, харилцан санал солилцох боломжийг бүрдүүлсэн байх	Тухай бүр	Яамны газрууд	
		Саналыг хэрхэн тусгасаныг тайлагнах	Тухай бүр	Яамны газрууд	
5	ЭХЯ-наас гадагш чиглэсэн хяналт шалгалт /хаана, ямар хяналт шалгалт хэрэгжүүлэх тухай нэрээр дурдаж бичих/	2017 онд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах	Жилдээ	ХШҮДАГ	
		Хийсэн хяналт шалгалтынхаа үр дүнг олон нийтэд цахим хуудсаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэх	Жилдээ	ХШҮДАГ	
		Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ/дүгнэлт, акт, зөвөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар цахим хуудсаар мэдээлсэн байх	Жилдээ	ХШҮДАГ	
		ЭХЯ-ны 2017 оны төсөв	2017.01.10-ны дотор	Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн П.Жаргалсайхан	

6	Төсвийн орлого, түүний зарцуулалтыг, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг веб сайтад байршуулах	2017 оны төсвийн гүйцэтгэл			
		2018 оны төсвийн төсөл	2017.08.15	Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн П.Жаргалсайхан	
		2016 оны /жилийн эцсийн/ санхүүгийн тайлан	2017.04.01-ний дотор	СХ-ийн ерөнхий нягтлан бодонч П.Энхцэлмэг Нягтлан бодогч Б.Ганцэцэг	
		2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /бүрэн эрхээр/	2017.06.01-ний өдөр	Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн П.Жаргалсайхан Ерөнхий нягтлан бодонч П.Энхцэлмэг Нягтлан бодогч Б.Ганцэцэг	
		2017 оны төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл	2017 оны төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл	Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн П.Жаргалсайхан	
		Концессийн зүйлийн жагсаалт, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, гэрээний талаарх мэдээлэл	Батлагдсанаас хойш 14 хоногийн дотор	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Ж.Жанарбаатар	

		Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессийн зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг концессийн гэрээ байгуулсан тухай бүр цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Ж.Жанарбаатар	
		2016 онд гадаадын зээл, тусламжаар хэрэгжих болон хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр жагсаалтыг гаргаж АТГ-д ирүүлэх	2017.03.01-ний дотор	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Ж.Жанарбаатар	
		Дээрх төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг вебсайтад байршуулах	Тухай бүр	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Ж.Жанарбаатар ТЗУГ-ын мэргэжилтэн Б.Түмэнжаргал	
7	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийг үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжийг хангах	Тухайн байгууллагаас олгож байгаа зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох гм бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтын гаргах, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг цахим хуудас, мэдээллийн самбарт	Тухай бүр	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Л.Ариунжаргал	

		нээлттэй байршуулсан байх			
		Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болгох хугацааг цахим хуудсанд байршуулсан байх	Тухай бүр	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Л.Ариунжаргал	
		Хууль тогтоомжид зааснаар бүртгэл хийхээр тусгасан бүртгэлүүдийн /нууцад хамаарахаас бусад/ мэдээллийг ил тод, нээлттэйгээр цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан байх	Тухай бүр	Яамны газрууд	
8	Хүний нөөцийн ил тод нээлттэй байдлыг хангах	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	Тухай бүр	ТЗУГ-ын Мэргэжилтэн Д.Чимидлхам	
		Сонгон шалгаруулалт явуулах талаар цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	Тухай бүр	ТЗУГ-ын Мэргэжилтэн Д.Чимидлхам	
		Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлэх үйл ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулах	Төлөвлөсөн хугацаанд	ТЗУГ-ын Мэргэжилтэн Д.Чимидлхам	
		Тайлант хугацаанд томилогдсон албан тушаалтны жагсаалт, ажил үүргийн чиглэлийн	2017.11.15	ТЗУГ-ын Мэргэжилтэн Д.Чимидлхам	

		жагсаалт гаргаж АТГ-д ирүүлэх			
9	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	Худалдан авах ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг нийтэд зарлах, веб сайтад байршуулах	Төсөв батлагдсанаас хойш 1 сарын дотор	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс Мэргэжилтэн Б. Отгонцэцэг	
		Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	Тухай бүр	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс Мэргэжилтэн Б. Отгонцэцэг	
		Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан үндэслэлийн талаарх мэдээллийг ил тод мэдээлэх	Тухай бүр	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс Мэргэжилтэн Б. Отгонцэцэг	
		Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийг танилцуулах	Тухай бүр	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс Мэргэжилтэн Б. Отгонцэцэг	
		Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсанд байршуулсан байх	Тухай бүр	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс Мэргэжилтэн Б. Отгонцэцэг	

		Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэх	Тухай бүр	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс Мэргэжилтэн Б. Отгонцэцэг	
		Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх	Тухай бүр	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс Мэргэжилтэн Б. Отгонцэцэг	
		Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах	Тухай бүр	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс Мэргэжилтэн Б. Отгонцэцэг	
10	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлсэн байх	Төлөвлөсөн хугацаанд	ТЗУГ-ын мэргэжилтэн Д.Батмөнх	
		Албан хаагчдын хариуцсан ажил, үүргийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх	4-5 сард	ТЗУГ-ын мэргэжилтэн Б.Түмэнжаргал	
11	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогоон мөрдөх	Зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах нөхцөл боломжийг бүрдүүлэх, зөрчлийн бүртгэл хөтлөх, зөрчлийг шийдвэрлэх, хариуцлага тооцох,	Тухай бүр	Хуулийн хэлтсийн дарга, ЭБАТ Н.Бямбадорж	

		зөрчлийг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах, хамт олонд мэдээлэх			
		Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалт болон Давхар ажил эрхлэх зөвшөөрлийг олгох, давхар ажил эрхлэлтийн судалгаа гаргах	Тухай бүр	Хуулийн хэлтсийн дарга, ЭБАТ Н.Бямбадорж	
		Эрчим хүчний сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал /нууцад хамааруулснаас бусад/-ыг цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	Сайдын туслах Ж.Товуудорж ТНБД-ын туслах Ж.Баттулга ТЗУГ-ын мэргэжилтэн Б.Түмэнжаргал	
12	Авилгын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлэх, Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авах	Тухай бүр	Хуулийн хэлтсийн дарга, ЭБАТ Н.Бямбадорж	
13	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй		Тухай бүр нэн даруй	Хуулийн хэлтсийн дарга, ЭБАТ Н.Бямбадорж	

	холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх				
14	Авилгатай тэмцэх газраас бүрэн эрхийн дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмж болон АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдэл	Тухай бүр	Хуулийн хэлтсийн дарга, ЭБАТ Н.Бямбадорж	
		Зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичиг болон Хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичиг	Тухай бүр	Хуулийн хэлтсийн дарга, ЭБАТ Н.Бямбадорж	
		Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох	Тухай бүр	Хуулийн хэлтсийн дарга, ЭБАТ Н.Бямбадорж	
		АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд	Тухай бүр	ТЗУГ	

		өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ын хэрэгжилт			
15	Өргөдөл/ санал, мэдэгдэл/, гомдол хүсэлтийг хүлээн авах шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэхэд чиглэсэн арга хэмжээ	Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сурталчлах	Тухай бүр	ТЗУГ-ын мэргэжилтэн Д.Чимидлхам	
		Өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх /утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар гм/	2 дугаар улирал	ТЗУГ-ын мэргэжилтэн Д.Чимидлхам Мэргэжилтэн Б.Түмэнжаргал	
		Үйлчилгээ, захидал харилцаа хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	4-5 дугаар сар	ТЗУГ-ын мэргэжилтэн Д.Чимидлхам Мэргэжилтэн Б.Түмэнжаргал	
		Бусад этгээдээс шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн өргөдлийн шийдвэрлэлтийн талаар цахим хуудсаар мэдээлэх	Улирал тутам	ТЗУГ-ын мэргэжилтэн Б.Түмэнжаргал	
		Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсаар мэдээлэх	Улирал тутам	ТЗУГ-ын мэргэжилтэн Б.Түмэнжаргал	

16	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэх эрмэлзлэл, хүчин чармайлт, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх	Авилагын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх	Тухай бүр	Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан	
		Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авах	Тухай бүр	Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, ХХ-ийн дарга, ЭБАТ Н.Бямбадорж, ТЗУГ-ын мэргэжилтэн Д.Чимидлхам	
		Эрх бүхий албан тушаалтныг ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангах	Тухай бүр	Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, ТЗУГ-ын дарга М.Баярмагнай	
17	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлтийг болон Авлигатай тэмцэх газраас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийг хангуулах	Тухай бүр	Хуулийн хэлтсийн дарга, ЭБАТ Н.Бямбадорж	
		Авлигатай тэмцэх газраас авлига гарах нөхцөл		Хуулийн хэлтсийн	

		боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох	Тухай бүр	дарга, ЭБАТ Н.Бямбадорж	
		Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ын биелэлтийг хангуулж ажиллах	Тухай бүр	Хуулийн хэлтсийн дарга, ЭБАТ Н.Бямбадорж	
18	Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл болон бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх. /Авлигатай тэмцэх үйл ажиллагааны зардлыг 2018 оны төсвийн төсөлд суулгах зэрэг/	Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлант хугацаанд	Бүх газар, хэлтсүүд	

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ